




ЗӨВШӨӨРӨВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Д.ОЧИРБАТ

БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НҮҮР АМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Б.БАЯРЧИМЭГ



ШҮДНИЙ ЭМЧИЙН
“НҮҮР АМНЫ МЭС ЗАСАЛ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: S(r)-0911-02/

ХУГАЦАА: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ

Ш.Даваахүү	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн Нүүр амны мэс заслын тэнхмийн эрхлэгч, Анагаах ухааны доктор
Б.Батбаяр	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн захирал, Анагаах ухааны доктор, дэд профессор
Л.Хэнтий	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Нүүр амны мэс заслын тасгийн зөвлөх эмч, Монголын эрүү нүүрний мэс засалчдын нийгэмлэгийн ерөнхийлөгч, Анагаах ухааны доктор, дэд профессор
Г.Аянга	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүү нүүрний мэс заслын тасгийн эрхлэгч, Анагаах ухааны доктор
Э.Уламбаяр	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эрүү нүүрний мэс заслын их эмч, Тэргүүлэх зэргийн эмч

ХЯНАСАН:

Н.Дашдондов	Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Салбарын хүний нөөцийн сургалт, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн
01 дүгээр тогтоолоор зөвшөөрөв.

НҮҮР АМНЫ ИХ ЭМЧИЙН “НҮҮР АМНЫ МЭС ЗАСАЛ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

Монгол улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд цаашид ямар мэргэшлийн чиглэл сонгон суралцаж, хаана ажиллахаас үл хамааран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон талт, цогц, уян хатан байдлаар үзүүлэх чадвартай нүүр амны мэс заслын их эмч бэлтгэх шаардлагатай байна.

Улсын Их Хурлаас 2016 онд шинээр баталсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-аар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, эмнэлгийн үндсэн үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ явуулах түүнчлэн төгсөлтийн дараах сургалт эрхлэхээр зохицуулсан тул “Нүүр амны мэс засал судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтыг зохион байгуулж, төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын хүрээг тэлэх боломж бүрдсэн болно.

Эрүүл мэндийн сайдын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн А/485 тушаалаар Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах, тусламж үйлчилгээний жагсаалт гарсан бөгөөд Нүүр ам судлалын төв эмнэлэг болон Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг (УНТЭ)-ийн Эрүү Нүүрний Мэс Засал (ЭНМЗ)-ын тасагууд нь сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах үүрэг хүлээсэн.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр тушаалаар “Нүүр амны мэс засал судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг шинэчлэн баталсан ба Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дүгээр тушаалаар “Нүүр амны мэс засал судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтыг 2 жилийн хугацаатай байхаар заасан тул сургалтын хөтөлбөрийг шинэчилж байсан.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 10-ны өдрийн А/774 тушаалаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг дахин шинэчлэн боловсруулахаар заасан тул энэхүү сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсрууллаа.

Хоёр. Эрхэм зорилго

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцэх үндсэн мэргэшлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх цогц чадвар бүхий нүүр амны мэс заслын эмч бэлтгэх.

Гурав. Алсын хараа

“Нүүр амны мэс засал судлал”-ын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:

Эрүү нүүр орчмын зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлогоо эмчилгээний сүүлийн үеийн дэвшилтэт арга, технологиудыг нэвтрүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон, эрүү нүүр амны эд эрхтэнүүдийн эрүүл ба эмгэг байдлыг үнэлэх, ангилах, оношлох, эмчлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг ур чадвар эзэмшсэн, гардан үйлдэлд дадлагажсан, бусад мэргэжлийн эмч нарт мэргэжлийн зөвлөгөө өгөх чадавхитай, өвчтөнд энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан үндсэн мэргэшлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг эмч байна.

Дөрөв. Монгол Улсын “Нүүр амны мэс засалч эмч”-ийн чадамж

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах чадамжтай байна:

1. Нүүр амны мэс заслын мэргэшлийн эмч (*Oral & Maxillofacial Surgeon*)
2. Мэргэжилтэн (*Professional*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Нийгмийн эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч (*Organizer*)
8. Манлайлагч (*Leader*)

Чадамж (Competency): Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар, үнэ цэнэ, хандлага зэрэг олон бүрэлдэхүүн хэсгийг агуулсан, ажиглагдахуйц хүчин чадал, чадвар. Нэгэнт чадамж нь харагдахуйц тул түүнийг хэмжиж, эзэмшсэн эсэхийг үнэлж болно. Мөн чадамжийг хэрхэн эзэмших, хөгжихийг зааж чиглүүлж болно.

Тав. Сургалтын зорилт

Цөм чадамж бүхий нүүр амны мэс заслын эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1. Нүүр амны мэс заслын мэргэшлийн эмч (*Oral & Maxillofacial Surgeon*)
 - Нүүр амны мэс заслын практикт зайлшгүй шаардлагатай хүний биеийн байршлын анатоми, толгой, хүзүү, эрүү, нүүр орчмын анатомийн талаар гүнзгийрүүлэн суралцаж мэдлэг олох;
 - Нүүр амны мэс заслын практикт шаардлагатай физиологи, патологи, микробиологийн суурь үндсэн ойлголт тэдгээрийн эмнэл зүйн уялдаа холбоог ойлгож суралцаж мэдлэгтэй болох;

- Мэс заслын яаралтай тусламж шаардах өвчнүүдийг цаг алдалгүй оношлон анхны тусламж үзүүлж, яаралтай мэс засал хийх мэдлэг, дадал, хандлага эзэмших;
- Мэс заслын тасгийн зохион байгуулалт, мэдээгүйжүүлэг, халдвар хамгаалал, үжил эсэргүүцэх арга, цус тогтоох арга зэрэг мэс заслын ерөнхий зарчимтай танилцаж, мэдлэг дадалтай болох
- Өвчтөнөөс асуумж авах, бодит үзлэг хийх, өвчтөний сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;
- Амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийж, зөвлөгөө өгөх;
- Өвчтөний хувийн нууцыг хадгалах;
- Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах;
- Дүрс оношлогоо, цусны шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр ямар хүнд ямар шаардлагаар авах талаар ойлголт мэдлэгтэй байх
- Ариутгал, халдваргүйжүүлэлтийн зарчим, ойлголт мэдлэгтэй байж түүнийгээ нүүр амны мэс заслын практикт хэрэгжүүлж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлж чаддаг байх
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон тайлангийн маягтыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх, цахим программ ашиглаж сурах
- Нүүр амны мэс заслын практикт тохиолдох амь тэнссэн үеийн тусламжийн гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээг аюулгүй, цаг алдалгүй үзүүлэх;
- Шүд авах мэс ажилбараас улбаатай хүндрэлүүд, шүд саатах талаар мэдлэг, чадвар, хандлагатай болох тусламж үйлчилгээг үзүүлэх;
- Эрүү, нүүр, хүзүү, толгой орчмын үрэвсэлт өвчнүүдийн талаар үндсэн мэдлэг, чадвар, хандлагатай болох яаралтай тусламж үзүүлэх чадвартай болох;
- Эрүү нүүр орчмын хугарал, мултрал, зөөлөн эдийн гэмтлийг оношлох ур чадварт суралцан, анхан шатны тусламж үзүүлж чаддаг байх;
- Шүлсний булчирхайн эмгэгүүдийн талаар мэдлэг, чадвар, хандлагатай болох;
- Тунгалгын булчирхайн эмгэгүүдийн талаар мэдлэг, чадвар, хандлагатай болох;
- Эрүүний үений эмгэгүүдийн талаар үндсэн мэдлэг, чадвар, хандлагатай болох;
- Толгой, хүзүү, нүүр, амны хөндийн хортой болон хоргүй хавдрыг эрт оношлон, түүний урьтал өвчнүүдийг мэдүүлэх, хавдраас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, чадвартай болох, тусламж үйлчилгээг үзүүлэх боломжгүй тохиолдолд дараагийн шатны эмнэлэг рүү зөв чиглүүлж журмын дагуу илгээж сурах;
- Нүүр амны мэдрэлийн эмгэгтэй танилцаж, оношлогоо, анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, чадвартай болох;
- Хүүхдийн эрүү нүүр орчмын эмгэгүүд, төрөлхийн гаж хөгжлүүд, тэдгээрт авах арга хэмжээ, эмчилгээ зөвлөгөө хүргэх чадвар, хандлага эзэмших
- Шүдний имплант эмчилгээний мэс заслын талаар үндсэн мэдлэг, чадвар, хандлагатай болох;
- Зуулт засах (ортогнатик) мэс заслын талаар үндсэн мэдлэг, ойлголтой болох;
- Мэсгүй гоо сайхны эмчилгээний талаар үндсэн мэдлэг, чадвар, хандлагатай болох
- Нүүрний гоо сайхны мэс заслын талаар үндсэн мэдлэг, ойлголттой болох

- Үс шилжүүлэн суулгах талаар үндсэн мэдлэг, ойлголттой болох
2. Мэргэжлийн (*Professional*)
 - Салбарын хөгжилд болон хөдөө, орон нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
 - Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах;
 - Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харьцах, өвчний талаарх мэдээллийг зөв ойлгуулах;
 3. Суралцагч (*Learner*)
 - Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд дотоод болон гадаадын мэргэжлийн нийгэмлэг, холбоод, их сургууль, эмнэлгийн зохион байгуулж буй тасралтгүй сургалтанд жил бүр хамрагдах;
 - Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшилээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлан, дүн шинжилгээ хийх;
 - Хамтран суралцагч эмч, мэргэжил нэгт бусад эмнэлгийн эмч нартаа заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах.
 4. Харилцагч (*Communicator*)
 - Өвдөж шаналсан, оношлуулж эмчлүүлэхээр ирсэн хүнтэй хэрхэн зөв харилцах харилцааны ур чадвартай болох
 - Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харьцах;
 - Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг, хэллэг ашиглан тайлбарлах;
 - Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар өөрийн болон бусад эмнэлгийн эмч мэргэжилтэнтэй зөвлөлдөх.
 5. Хамтрагч (*Collaborator*)
 - Тухайн хот, орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
 - Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллийг хуваалцаж хамтран ажиллах;
 - Монголын эрүү нүүрний мэс засалчдын нийгэмлэгийн болон бусад гадаад, дотоодын ижил мэргэжлийн нийгэмлэг байгууллагатай хамтран ажиллах;
 6. Нийгмийн эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)
 - Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах;
 - Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
 7. Зохион байгуулагч, манлайлагч (*Organizer, Leader*)
 - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
 - Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

Зургаа. Сургалтын арга зүй

6.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалт үргэлжлэх нийт хугацаа 2 жил буюу 88 долоо хоног байна.
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн шийдвэрээр “Нүүр амны мэс засал судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллага нь энэхүү сургалт явуулах үндсэн байгууллага байна.
- Хөтөлбөрийн зарим агуулгын явуулах хангалттай орчин бүрдүүгүй тохиолдолд мэргэжлийн хичээлийн тойролтуудын 30 хүртэлх хувийг эрүүл мэндийн бусад байгууллагыг түшиглэн явуулж болно.
- Тойролтын хугацааг тухайн сургалт эрхлэх эмнэлгүүдийн Нүүр амны мэс заслын тасаг, Хүүхдийн эрүү нүүрний мэс заслын тасаг, Толгой хүзүү, нөхөн сэргээх мэс заслын тасаг мэс заслын тасаг, Гавал тархины гэмтлийн тасаг, амбулатор, тасгийн үзлэгийн болон хагалгааны хэсэг, анги танхим, хурлын заал, номын сангийн хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг сургалт эрхлэх алба, тасаг боловсруулна.
- Суралцагч нь сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууц, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, жендерийн тэгш байдалтай холбоотой хууль, журам, Эмнэлгийн эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, радиологи оношилгооны аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд (orientation) заавал хамрагдана.

6.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, суурь мэдлэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд бие даан тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сурлагч багшийн хяналт дор амбулаториор ирэх өвчтөн, хэвтэн эмчлүүлэх өвчтөний оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

6.2.1 Шинж тэмдэг (signs and symptoms) (аль ч тойролтод тохиолдох):

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношлогоо, эмчилгээ хийж чаддаг болох;

1. Халууралт (*Fever*)
2. Толгой өвдөлт (*Headache*)
3. Дотор муухайралт, бөөлжилт (*Nausea, Vomitting*)
4. Ухаан алдалт, баларталт (*Altered level of consciousness*)
5. Амьсгаадалт (*Dyspnea*)
6. Цээжээр өвдөх (*Chest pain*)
7. Амьсгалын зам саадтай болох (*Airway disturbance*)
8. Залгих үйл алдагдах (*Swallowing disturbance*)

9. Зажлах үйл алдагдах (*Chewing disturbance*)
10. Нүд бүлтийх (*Exophthalmos*)
11. Нүд хоёрлож харах (*Diplopia*)
12. Таталт (*Seizure*)
13. Шингэн алдалт (*Dehydration*)
14. Зүрх зогсолт (*Cardiac arrest*)
15. Хаван (*Edema*)
16. Үрэвслийн гаралтай арьс улайлт (*Fasciitis*)
17. Ам ангайлт хязгаарлагдах (*Trismus*)
18. Цус алдалт (*Hemorrhagic tendency*)
19. Лимфийн булчирхай томролт (*Lymph node swelling*)
20. Сэтгэл гутрал (*Depression*)
21. Албадмал байрлал (*Limited neck movement*)
22. Эрүүний мултрал (*Temporomandibular joint dislocation*)

6.2.2 Суурь шинжлэх ухааны мэдлэгийг сэргээх

Толгой хүзүү орчмын анатоми, физиологи, патологи, эм зүй судлалын чиглэлээр бие даалт хийн суурь шинжлэх ухааны мэдлэгийг сургалтын эхний 2 сард түлхүү зааж сэргээнэ.

1. Анагаахын клиникийн шинжлэх ухаан: Энэхүү хичээлийг суурь шинжлэх ухааны мэдлэг батжуулахтай зэрэгцэн эхний жилд заана.

- **Дүрс оношлогоо:** Суралцагч эмч нь эрчимт эмчилгээний тасагт багадаа 2 долоо хоног тойролт хийх бөгөөд лекц, семинар, клиникийн материал болон дүрс оношлогооны зураг уншиж тайлбарлаж сурах, цацрагийн аюулгүй байдлын талаар сурж, ахисан дүрс оношлогооны аргыг эзэмшүүлэх зорилготой.
- **Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, амилуулах сургалт:** Суралцагч эмч нь эрчимт эмчилгээний тасагт багадаа 2 долоо хоног тойролт хийх бөгөөд энэ нь яаралтай тусламж хэрхэн үзүүлэх, амилуулах тусламж хэрхэн үзүүлэх, хүнд өвчтөнүүдийн эмчилгээний зарчимуудаас суралцана.

2. Чих хамар хоолойн болон нүд судлалын мэс засал: Суралцагч эмч нь Чих хамар хоолой болон Нүд судлалын тасагт тус бүр 7 хоног бүх үйл ажиллагаанд оролцож тойролт хийснээр Чих хамар хоолой, нүд судлалын талаар ерөнхий ойлголттой болно.

3. Мэдээгүйжүүлэг: Суралцагч эмч ерөнхий мэдээ алдуулалтын багийн гишүүн болж ажиллах бөгөөд өвчтөнийг мэдээ алдуулалтын өмнө урьдчилан сэргийлэх үнэлгээ өгөх талаар боловсрол олгоно. Ерөнхий унтуулга болон эрчимт эмчилгээний тасагт 2 долоо хоногийн хугацаанд тойролт хийж, хэсгийн мэдээгүйжүүлэлтийн аргуудыг төгс эзэмшиж, заалтын дагуу тогтсон өвдөлтийн менежментийн тухай ойлголттой болох.

- Хэсгийн мэдээ алдуулалт

- Хэсгийн мэдээ алдуулалтанд өргөн хэргэлэгддэг эм тариа, тун хэмжээ, хэрэглэх заалт
- Судас нарийсгагч эм хэрэглэх, тун хэмжээ, заалт, эсрэг заалт
- Хэсгийн мэдээ алдуулалтын аргууд (түрхэх, тарих, хөлдөөх, шүрших гэх мэт)
- Хэсгийн мэдээ алдуулалтаас гарах хүндрэлүүд, авах арга хэмжээ
- Харшлын улбаатай шокийн эмгэг жам, эмнэл зүй, авах арга хэмжээ
- Ерөнхий мэдээ алдуулалт
 - Ерөнхий мэдээ алдуулалтын төрлүүд, эм тарианууд, хэрэглэх заалтууд
 - Амны хөндийн мэс засал, нүүрний гэмтэл, ам ангайлт хязгаарлагдсан болон эрүүний үе бороолсон тохиолдолд интубаци тавих аргууд
 - Амьсгал боогдох, бүтэх, цусны даралт ихсэх, багасах, зүрхний хэм алдагдах зэрэг хүндрэлээс урьдчилан сэргийлж, дээрхи хүндрэлийн үед мэдээгүйжүүлгийн эмчтэй хамтран авах арга хэмжээнд суралцах.

4. Мэс заслын суурь мэдлэг: Мэс заслыг халдвар хамгааллын дүрэм дагуу хийж сурах, мэс заслын өрөөнд биеэ зөв авч явах, мэс заслын бэлтгэл ажлуудыг зөв хийж сурах

- Үжилгүйжүүлэх, үжил эсэргүүцэх. Халдвар тархах зам.
- Нүүр амны мэс засалд хэрэглэгддэг онцлог багаж, тэдгээрийг ариутгах, хадгалах
- Мэс засал хийхийн өмнө гар угаах, бээлий өмсөх арга
- Нүүр амны мэс заслын талбайг ариутгах уусмал, тэдгээрийг хэрэглэх заалт
- Нүүр амны мэс засалд хэрэглэгддэг ариун даавууны төрөл, тэдгээрийг хэрэглэх
- Мэс заслын ширээг засч бэлтгэх, багажыг байрлуулах
- Оёдлын утас, тэдгээрийг нүүр амны мэс засалд хэрэглэх, арга техник, оёдол авах

5. Мэс заслын өмнөх үе: Суралцагч эмч нь ажлын өдрийн турш эмнэлзүйн сургагч багш нарын удирдлаган дот өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэх, эмчилгээний талаар мэдээлэл өгөх, таниулсан зөвшөөрөл авах, эмнэлгээс гаргах, өвчтөнг хагалгаанд бэлтгэж мэс заслын улбаатай хүндрэл гаргахаас урьдчилан сэргийлэх, амин үзүүлэлтүүдийг хянах, эмчилгээний явцыг шалгаж, эдгээр мэдлэг чадварыг эхний улиралд эзэмшсэн байх шаардлагатай.

- Нүүр амны мэс заслын өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэх заалт
- Нүүр амны мэс заслын яаралтай ба төлөвлөгөөт хагалгаа, тэдгээрийн онцлог
- Нүүр амны мэс заслаас улбаалж хүндрэлд хүргэх нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс
- Лабораторийн шинжилгээнүүдийн хэвийн ба эмгэг өөрчлөлтүүдийг ялгах, дүгнэх
- Дүрс оношилгооны хэвийн болон эмгэг өөрчлөлтийг ялгах, дүгнэх
- Нүүр амны мэс засал хийхээс өмнө бусад нарийн мэргэжлийн эмч нартай зөвлөлдөх

- Нүүр амны мэс заслыг гажиг, согог засал, шүдний тулгуур эд, сувгийн эмчилгээтэй хавсрах, түүнд бэлтгэх
- Нүүр амны мэс засалд өргөн хэрэглэгддэг мэдээ алдуулалт, заалт, сонголт
- Хэсгийн мэдээ алдуулалт хийхийн өмнөх эмжүүлэг (нейролептик, атарактик, гипнотик) хэрэглэх заалт, сонголт
- Цус, цусны төрлийн бэлдмэл захиалах, хэрэглэх заалт, эсрэг заалт
- Өвчтөнг угааж арчлах, үс хусах, хоол сойх, бургуй тавих, ходоодонд гуурс тавих, амны хөндийг эрүүлжүүлэх, шүдэлбэрийг авах гэх мэт заалтууд
- Нүүр амны мэс заслын өмнөх үеийн өвчтөний сэтгэл зүйн байдлыг тодорхойлох, түүнийг удирдан чиглүүлэх, сэтгэл засал хийх

6. Мэс заслын дараах үе: Мэс заслын дараа өвчтөнд тавих анхаарлыг төвлөрүүлэх. Мэс заслын улмаас өвчтөний биед гарах өөрчлөлтүүдийг зөв үнэлж дүгнэх. Эмчилгээ үйлчилгээг зүй зохистой явуулж хагалгааны дараа гарч болзошгүй хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон хүндрэлийг эмчлэх. Амин чухал үзүүлэлтүүдийг хянах, өвчтөн эмчийн хамтын ажиллагаа, хяналт хийх, зөвлөгөө өгөх зэрэг орно. Эдгээр мэдлэг чадварыг багшийг даган суралцаж, эхний жилдээ эзэмшсэн байх шаардлагатай.

- Мэс заслын дараа хүндрэл тохиолдоогүй бол
 - Нүүр амны мэс заслын дараах өвчтөний биеийн ерөнхий ба хэсэг газрын байдлыг дүгнэх
 - Нүүр амны мэс заслын дараах өвчтөнд хийх эмчилгээ үйлчилгээний заалт, өвчтөнг хэвтэрт байлгах зайлшгүй шаардлага, өвчтөний хоолны төрөл ба хооллох аргууд, өвчин намдаах, жин тавих, ам хамрын хөндийн цэвэрлэх
 - Нүүр амны мэс заслын дараа өргөн хэрэглэгддэг эм тарианы тун хэмжээ, хэрэглэх заалт, гажиг, согогийн зэмсэгүүд болон чиг хянаж шалгах
 - Нүүр амны мэс заслын өвчтөний шархыг цэвэрлэж арчлах ерөнхий зарчим, арга техник, боолтын төрөл
 - Шарх эдгэрэлтийг удаашруулах нөхцөлд дүгнэлт хийж, түүний эсрэг авах арга хэмжээ
 - Нүүр амны мэс заслын өвчтөнг эмнэлгээс гаргах заалт, амбулаториор хянах, хөдөлмөрийн чадвар алдалтыг үнэлж дүгнэх
- Мэс заслын дараах хүндрэл тохиолдвол
 - Нүүр амны мэс заслын дараа өвчтөнд тохиолдох ерөнхий хүндрэл (амьсгал, зүрх судас, цус бүлэгнэлттэй холбоотой, хүчил-шүлтийн тэнцвэр алдах гэх мэт хүндрэл), эмнэлзүйд хийх шинжилгээнүүд, эмчилгээ
 - Мэс заслын дараа өвчтөн бөөлжих үед эрүү хоншоорын бэхэлгээг авах арга техник
 - Нүүр амны мэс заслын шарх бохирдсон эсэхийг тодорхойлох, тийм бол авах арга хэмжээ

- Оёдол сулрах, шарх задрах, авах арга хэмжээ
- Нүүр амны мэс заслын дараа хүндрэл тохиолдсон өвчтөнг эмнэлгээс гаргах заалт, амбулаторийн хяналтанд шилжүүлэх

6.2.3 Өвчин (тойролт тус бүрээр)

Суралцагч эмч эрүү нүүрний мэс заслын тасгийн бүхий л үйл ажиллагаанд идэвхитэй оролцох бөгөөд зөвхөн эмнэл зүйн сургагч багш, дагалдах эмчийн удирдлага хяналт дор амны хөндийн мэс ажилбар, бусад мэс ажилбаруудыг хийж гүйцэтгэх үүрэгтэй. Үүнд:

- Өвчин тус бүрийн талаар зөвлөгөө өгч, оношилж, эмчлэх, эрэмбэлж шийдвэр гаргаж сурах;
- Нүүр амны мэс заслын практикт чухал байр суурь эзэлдэг, хүндрэл нь цаг минутаар тооцогддог эрүү, нүүр, толгой, хүзүү орчмын буглаа, нэвчээсийн хүндрэлийн үед эмчилгээний зөв менежмент боловсруулж, мэс заслын тусламжийг цаг алдалгүй хүргэхэд суралцах ёстой;
- Эрүү нүүр орчмын гэмтлийн менежмент чухал үүрэгтэй бөгөөд суралцагч эмч үргэлж яаралтай тусламжт хэрэгтэй өвчтөнг оношлох, эмчлэхэд бэлэн байх ёстой;
- Эрүү нүүр орчим тохиолддог эмгэг үүсгэвэрийн оношлогоо, эмчилгээний зарчмыг мэдэх, эд эсийн шинжилгээ авч онош тодруулж сурах, хортой хавдар илрүүлсэн тохиолдолд цаг алдалгүй дараагийн шатлалын эмч, эмнэлэгч өвчтөнийг шилжүүлж сурах;
- Доод шатлалын эмнэлэгт ажиллаж байгаа үед хэрхэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, дээд шатлалын эмнэлэгт өвчтөн шилжүүлэх заалтыг мэддэг болох, телемедицин ашиглан дээд шатлалын эмнэлгийн эмч нараас зөвлөгөө авч хэрэгжүүлдэг байх, дээд шатлалын эмнэлэгт өвчтөнг аюулгүйгээр шилжүүлэх аргад суралцах;
- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнд өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед нь илрүүлэх талаар зааж, зөвлөгөө өгөхөд суралцах

Тойролт 1. Эрүү нүүр орчмын хэсгийн мэдээгүйжүүлэлт. Шүд авах арга барил

Тойролтын агуулга:

- Илүү шүд (Supernumerary tooth) – K0.01
- Саатсан шүд (Impacted tooth) – K01.0
- Сурвалжийн оройн үрэвсэл (Periodontitis) – K04.5
- Перикоронарит (Pericoronitis) – K05.2
- Холбоосын аргах үрэвсэл (Chronic periocoronitis) - K05.3
- Тулгуур эдийн үрэвсэл (Paradontosis) – K06.0
- Шүдний байрлалын гажиг (Anomalies of tooth position) – K07.3
- Ясны хальсны үрэвсэл (Dental abscess) – K10.2
- Ясны идээт үхжилтэт үрэвсэл (Osteomyelitis) – K10.3
- Эрүү нүүр орчмын нэвчээс (Cellulitis of face) – L03.2

- Тунгалгийн булчирхайн үрэвсэл (Lymphadenitis) – L04.0
- Хоншоорын хөндийн үрэвсэл, гайморит (Sinusitis) – J32.0
- Шүдний хугарал (Fracture of tooth) – S02.5
- Эрүү ясны хугарал (Fracture of mandibular bone) – S02.6
- Шүдний мултрал (Dislocation of tooth) – S03.2

Тойролт 2. Эрүү нүүр орчмын шүдний бус гаралтай үрэвсэлт өвчин . Шүдний имплант. Мэсгүй гоо сайхны эмчилгээ

- Шүлсний булчирхайн үрэвсэл (Sialadenitis) – K11.2
- Шүлсний булчирхайн буглаа (Abscess of salivary gland) – K11.3
- Шүлсний булчирхайн цоорхой (Fistula of salivary gland) – K11.4
- Шүлсний булчирхайн чулуу (Sialolithiasis) – K11.5
- Афтозны стоматит ХРАС (Aphtoes stomatitis) – K12.0
- Уруулын өвчин, хейлит (Diseases of lip, cheilitis, cheilosis) – K13.0
- Хэлний өвчин, глоссит (Diseases of tongue, glossitis) – K14.0
- Хатиг, мундас (Furunculus, carbunculus) – L02.0
- Тунгалгийн булчирхайн үрэвсэл (Lymphadenitis) – L04.0
- ТВС булчирхайн (TBC lymph node) – A15.4
- Шүдгүйдэл (Partial loss of teeth)- K08.401
- Шүдний импланттай (Presence of dental implant)- Z96.5
- Шүдний имплант суларсан, унасан (Osseointegration failure of dental implant)- M27.61
- Түүшин сэртэн шимэгдэх (Horizontal alveolar bone loss)- K06.3

Тойролт 3. Эрүү нүүр орчмын өвчтөнд ерөнхий мэдээгүйжүүлэлт. Эрүү чамархайн үений эмгэг. Дүрс оношилгоо

- Эрүүний үений эмгэг (Temporomandibular disorder) – M26.6
- Эрүү чамархайн үений бороо (Adhesions and ankylosis of temporomandibular joint) M26.61
- Эрүү чамархайн үений өвдөлт (Arthralgia of temporomandibular joint) M26.62
- Эрүү чамархайн үений жийргэвчийн эмгэг (Articular disc disorder of temporomandibular joint) M26.63
- Эрүү чамархайн үений үрэвсэл (Arthritis of temporomandibular joint) M26.64

Тойролт 4. Эрүү нүүр орчмын шүдний гаралтай үрэвсэлт өвчин

- Сурвалжийн оройн үрэвсэл (Periodontitis) – K04.5
- Перикоронарит (Pericoronitis) –K05.2
- Холбоосын аргах үрэвсэл (Chronic periocoronitis) - K05.3
- Тулгуур эдийн үрэвсэл (Paradontosis) – K06.0
- Ясны хальсны үрэвсэл (Dental abscess) – K10.2
- Ясны идээт үхжилтэт үрэвсэл (Osteomyelitis) – K10.3
- Амны хөндийн буглаа (Cellulitis, abscess of the mouth) – K12.2
- Эрүү нүүр орчмын нэвчээс (Cellulitis of face) – L03.2

- Хоншоорын хөндийн үрэвсэл, гайморит (Sinusitis) – J32.0

Тойролт 5. Эрүү нүүр орчмын хавдар, нөхөн сэргээх мэс засал

- Эпулис (Epulis) – K06.8
- Салстын уйланхай (Cyst of oral region) – K09.0
- Хамар тагнайн уйланхай (Nonodontogenic cyst) – K09.1
- Дермояд киста (Dermoid cyst) – K09.8
- Шүлсний булчирхайн уйланхай (Mucocoele, Ranula) – K11.6
- Уруулын хоргүй хавдар (Benign neoplasm of lip) – D10.0
- Хэлний холгүй хавдар (Benign neoplasm of tongue) – D10.1
- Амны ёроолын хоргүй хавдар (Benign neoplasm of floor of mouth) – D10.2
- Шүлсний булчирхайн хоргүй хавдар ((Benign neoplasm of salivary gland, Pleomorphic adenoma, Warthin's tumor) – D11.2
- Ясны хоргүй хавдар (Benign neoplasm of jaw bone) – D16.5
- Липом (Lipoma) – D17.0
- Гемангиома (Hemangioma) – D18.0
- Лимфангиома (Lymphangioma) – D18.1
- Фибром (Fibroma) – D21.0
- Мэнгэ (Nevus) – D22.3
- Атерома (Ateroma) – D23.0
- Уруулын хортой хавдар (Malignant neoplasm of lip) – C00.0
- Хэлний хортой хавдар (Malignant neoplasm of tongue) – C01.0
- Амны салстын хортой хавдар (Malignant neoplasm of gum) – C03.0
- Амны ёроолын хортой хавдар (Malignant neoplasm of floor of mouth) – C04.0
- Тагнайн хортой хавдар (Malignant neoplasm of palate) – C05.0
- Шүлсний булчирхайн хортой хавдар (Malignant neoplasm of Parotid gland & salivary gland) – C07.0 & C08.0
- Ясны хортой хавдар (Malignant neoplasm of jaw bone) – C41.0

Тойролт 6. Эрүү нүүр орчмын гэмтэл

- Ухархайн зөөлөн эдийн гэмтэл (Periocular injury) – S00.2
- Нүүрний зөөлөн эдийн ил шарх (Open wound of face) – S01.4
- Хамар ясны хугарал (Fracture of nasal bone) – S02.2
- Шанаа, хоншоор ясны хугарал (Fracture of Maxillary bone) – S02.4
- Шүдний хугарал (Fracture of tooth) – S02.5
- Эрүү ясны хугарал (Fracture of mandibular bone) – S02.6
- Эрүүний мултрал (Dislocation of jaw) – S03.0
- Шүдний мултрал (Dislocation of tooth) – S03.2
- Гурамсан мэдрэлийн гэмтэл (Injury of trigeminal nerve) – S04.3
- Нүүрний мэдрэлийн гэмтэл (Injury of facial nerve) – S04.5
- Зулгаралт, хөлдөлт (Crushing injury of face and head) – S07.0

Тойролт 7. Галт зэвсгийн гэмтэл, амь тэнссэн үеийн тусламж

Тойролт 8. Нүүрний болон гурамсан мэдрэлийн эмгэг

- Гурамсан мэдрэлийн гэмтэл (Injury of trigeminal nerve) – S04.3
- Нүүрний мэдрэлийн гэмтэл (Injury of facial nerve) – S04.5

Тойролт 9. Гоо сайхны мэс засал, ортогнатик мэс заслын эмчилгээ

- дээд зовхины унжилт
- доод зовхины унжилт
- духны унжилт
- нүүрний арьсны унжилт
- хүзүүний арьсны унжилт
- намхан хамар
- монхор хамар
- хамрын сартгар
- хамрын хэлбэр алдагдал
- чихний дэлдэн
- чихний хэлбэр алдагдал
- уруулын хэлбэр алдагдал
- Буруу зуулт (Dentofacial functional abnormalities) – K07.5
- Шаамий эрүү (Jaw deformity) – K10.0
- Таталдсан сорви (Scar condition, Keloid scar) – L90.5
- Үс уналт (alopecia)- L64
- Хөлрөлт (hyperhidrosis) - L74.511

Тойролт 10. Хүүхдийн нүүр амны мэс засал

- Илүү шүд (Supernumerary tooth) – K0.01
- Саатсан шүд (Impacted tooth) – K01.0
- Сурвалжийн оройн үрэвсэл (Periodontitis) – K04.5
- Шүдний байрлалын гажиг (Anomalies of tooth position) – K07.3
- Ясны хальсны үрэвсэл (Dental abscess) – K10.2
- Тунгалгийн булчирхайн үрэвсэл (Lymphadenitis) – L04.0
- Гахайн хавдар (Mumps) - B26.9
- Цогро, свиш (Fistulae) – Q18.5
- Хүзүүний төрөлхийн уйланхай (Branchial cyst) – Q18.8
- Тагнайн сэтэрхий (Cleft palate) – Q35.0
- Уруулын сэтэрхий (Cleft lip) – Q36.0
- Уруул тагнайн сэтэрхий (Cleft lip and palate) – Q37.0
- Хэлний богино хөвч (Ankyloglossia) – Q38.1

6.2.4 Гардан үйлдэл

Суралцагч эмч нь зөвхөн удирдагч багш, дагалдах эмчийн удирдлага хяналт дор боолт хийх, амны хөндийн мэс ажилбар, бусад мэс ажилбаруудын явцад гардан үйлдэл хийж гүйцэтгэн суралцах үүрэгтэй. (ICD үйлдлийн ОУ-ын ангилалын код)

1. Мэс заслын аргаар шүд авах – 23.1
2. Үлдэгдэл ёзоор авах – 23.11
3. Саатсан шүдийг мэс заслын аргаар авах – 23.19
4. Шүдний сурвалжийн орой тайрах – 23.73
5. Түүшин яс тэгшлэх, хэлбэржүүлэх – 24.5
6. Буйл түүшин сэртэнгээс эдийн шинжилгээ авах – 24.11
7. Буйлны шарх оёх – 24.32
8. Эрүү нүүр орчмын буглаа, нэвчээс нээх, урсгуур тавих – 27.0
9. Хэлнээс нээлттэйгээр эдийн шинжилгээ авах – 25.02
10. Хатуу зөөлөн тагнай, хүүхэн хэлнээс эдийн шинжилгээ авах – 27.21
11. Нүүрний ясны эдээс шинжилгээ авах – 76.11
12. Тунгалгийн булчирхайнаас эдийн шинжилгээ авах – 40.11
13. Тунгалгын булчирхайн авах – 40.4
14. Уруулын шарх оёх – 27.51
15. Хэлний шарх оёх – 25.51
16. Уруулын хөвч уртасгах – 27.91
17. Хэлний хөвч уртасгах – 25.92
18. Бранхиогенный уйланхай авах – 29.2
19. Тавдугаар мэдрэл таслах – 04.02
20. Нүүрний ясны хэлтэрхий авах – 76.01
21. Шүдний гаралтай эмгэг эдийг авах – 76.2
22. Шанаа ясыг битүү аргаар засах – 76.71
23. Шанаа ясыг ил аргаар засах – 76.72
24. Эрүүний хугарлыг битүү аргаар засах – 76.75
25. Эрүүний хугарлыг ил аргаар засах – 76.76
26. Түүшингийн хугарлыг ил аргаар засах – 76.77
27. Эрүүний үенд хийгдэх бусад ажилбар – 76.95
28. Шүдний ясан дах бэхэлгээ авах – 76.97
29. Секвестрэктомиа – 77.0
30. Миотомия – 83.02
31. Зөөлөн эдийг авах бусад ажилбарууд – 83.49
32. Атером, липом, дермояд киста авах – 86.0
33. Хамрын ясны хугарал засах – 21.72
34. Калдвел-Люкийн аргаар зажуурын хөндийн мэс засал хийх – 22.31
35. Ам хамрын дайвар хөндийн цоргыг битүүлэх – 22.71
36. Шүлсний булчирхай болон цоргыг нээх – 26.0
37. Шүлсний булчирхайн болон сувгаас эдийн шинжилгээ авах – 26.12
38. Шүлсний булчирхай бүрэн авах – 26.32
39. Чиг тавих – 93.54
40. Шүдэнд бэхэлгээ тавих – 93.55

41. Шарх угаах, боолт хийх – 97.16
42. Хамрын чихээс авах – 97.32
43. Миниплейт авах – 97.36
44. Оёдол авах – 97.38
45. Голтын урсгуур авах – 97.42
46. Ясыг өрөмдөж суулгац суух ором бэлтгэх арга техник
47. Шүдний суулгацыг ясанд суулгах арга техник
48. Шүдний суулгацыг эргэн авах арга техник
49. Шүдний суулгац суулгах үеийн яс нөхөх арга техник
50. Дээд зовхины мэс засал
51. Доод зовхины мэс засал
52. Дух өргөх мэс засал
53. Нүүр өргөх мэс засал
54. Хүзүү өргөх мэс засал
55. Ортогнатик мэс засал
56. Хамрын хэлбэр засах мэс засал
57. уруулын хэлбэр засах мэс засал
58. Чихний хэлбэр засах мэс засал

Тойролт хийх тасаг нэгж, хугацаа

№	Тойролтын жагсаалт	Тойролтын хугацаа /7 хоногоор/	Тойролт хийх тасаг нэгж, байгууллага
1	Эрүү нүүр орчмын хэсгийн мэдээгүйжүүлэлт. Шүд авах арга барил	8	Эрүү нүүрний мэс заслын тасаг
2	Эрүү нүүр орчмын шүдний бус гаралтай үрэвсэлт өвчин . Шүдний имплант. Мэсгүй гоо сайхны эмчилгээ	16	Эрүү нүүрний мэс заслын тасаг, Нүүр амны гажиг заслын тасаг мэс заслын тасаг
3	Эрүү нүүр орчмын өвчтөнд ерөнхий мэдээгүйжүүлэлт. Эрүү чамархайн үений эмгэг. Дүрс оношилгоо	8	Мэс заслын тасаг
4	Эрүү нүүр орчмын шүдний гаралтай үрэвсэлт өвчин	8	Эрүү нүүрний мэс заслын тасаг
5	Эрүү нүүр орчмын хавдар, нөхөн сэргээх мэс засал	8	Толгой хүзүү, нөхөн сэргээх мэс заслын тасаг мэс заслын тасаг
6	Эрүү нүүр орчмын гэмтэл	8	Гавал тархины гэмтлийн тасаг
7	Галт зэвсгийн гэмтэл, амь тэнссэн үеийн тусламж	8	Цэргийн Төв Эмнэлгийн Шүд, эрүү нүүрний тасаг

8	Нүүрний болон гурамсан мэдрэлийн эмгэг	8	Мэс заслын тасаг
9	Гоо сайхны мэс засал, ортогнатик мэс заслын эмчилгээ	8	Гоо сайхны мэс заслын тасаг
10	Хүүхдийн нүүр амны мэс засал	8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эрүү нүүрний мэс заслын тасаг

Ажлын байрны сургалт (On the job training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулторын үзлэг хийх	2	4 цаг, 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн, үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Амбулторын мэс засалд оролцох	1				
Гардан үйлдэл хийх	1-2				
Тасагт өвчний түүх нээж, мэс засалд хүнээ бэлдэх		1 цаг, 7 хоногт 5 удаа	Тасаг	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Яаралтай мэс засалд оролцох	1	2 цаг, 7 хоногт 2 удаа	Мэс заслын өрөө	Өвчтөн	
Гардан үйлдэл хийх	1-2	1 цаг, 7 хоногт 2 удаа	Тасаг, амбулатори, мэс заслын өрөө	Өвчтөн	
Унтуулгатай мэс засалд оролцох	1	6 цаг, 7 хоногт 3 удаа	Мэс заслын өрөө	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг, 7 хоногт 3 удаа	Тасаг	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, тасгийн эрхлэгч
Сургалтын тойрон үзлэг хийх	10 хүртэл	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө танхим	Слайд	
Боолт хийх	1	1 цаг, 7 хоногт 5 удаа	Тасаг болон амбулатори	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, боолтын сувилагч

Хяналтын тойрон үзлэг:

Хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч нарт) танилцуулах зорилготой үзлэг.

Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, өвчтөнтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид (бусад эмчид) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багштай (бусад эмчтэй) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг:

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

Танхимийн сургалт (Off the job training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой цаг, давтамж	Нээлттэй	Ном, интернет	Бие даан хийх
Лекц	10 хүртэл	7 хоногт 1 удаа, 1 цаг	Сургалтын танхим	Слайд	Эмнэл зүйн багш, суралцагч, эмч
Журнал клуб	10 хүртэл	7 хоногт 1 удаа, 1 цаг	Сургалтын танхим	IJOMS сэтгүүл, слайд	
Симуляц (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа, 1 цаг	Сургалтын танхим	Хамтран суралцагч, эмч	

Үйл ажиллагааны хуваарь (Schedule)

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
07:30-08:30	Хяналтын тойрон үзлэг		Журнал клуб		Журнал клуб
08:30-09:30	Мэс засалд оролцох		Мэс засалд оролцох		Хяналтын тойрон үзлэг
09:30-11:30		Амбулаторын обход			Амбулаторын үзлэг
11:30-12:30	Хяналтын тойрон үзлэг	Лекц, семинар	Хяналтын тойрон үзлэг		
13:30-16:00	Амбулатори & тасаг				
16:00-17:00			Симуляц		

Долоо. Үнэлгээ, эргэн зөвлөгөө

7.1 Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (*mentor*) цаашид “хариуцагч” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

7.2 Суралцагч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3 Үнэлгээний арга

7.3.1 Төгсөлтийн шалгалт

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулах “Нүүр амны мэс засал судлал”-ын сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтанд тэнцсэн тохиолдолд “Нүүр амны мэс засалын эмчийн” үнэмлэх олгоно.

7.3.2 Ажлын байранд суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтэн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Mini-CEX / Эмнэлзүйн дасгал үнэлгээ (*Mini-Clinical Evolution Exercise*):

Зайлшгүй таньж мэдэх 22 шинж тэмдэгээс тойролт бүрт 5-аас доошгүй шинж тэмдэгийг тус бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ

хийнэ. Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. (Жишээ нь: Нүүр амны мэс засал судлалын тойролтод ам ангайлт хязгаарлагдах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол Хүүхдийн Нүүр амны мэс засал судлалын тойролтод ч ам ангайлт хязгаарлагдах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно).

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас сурагцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөөг заавал өгнө.

Гардан үйлдлийн үр чадварын шууд ажиглалт / DOPS (*Direct observation of Procedural Skills*):

Зайлшгүй сурах 45 гардан үйлдлээс 35-аас доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас сурагцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөөг заавал өгнө.

Портфолио үнэлгээ (*Portfolio Assessment*):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтийг үр дүн болгож хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж хадгална.
- Сургагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтэгсний үндсэн дээр эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах

шинж тэмдэг, өвчний тохиолдол гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 22 шинж тэмдгээс 2 жилийн турш 18-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
 - Нүүр амны мэс засал судлал тойролтоор өвчний бүх тохиолдлыг тус бүр 3-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байх.
 - Хүүхдийн нүүр амны мэс засал судлал тойролтоор заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 2-оос доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байх.
 - Эрүү нүүр орчмын хортой хавдар тойролтоор заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 1-ээс доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байх.
 - Зайлшгүй суралцах 45 гардан үйлдлээс 2 жилийн турш 35-аас доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байх.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

Найм. Хэрэгжүүлэлт

(хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалтын албаны мэргэжилтэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын дэд дарга, “Нүүр амны мэс засал судлал” тойролтын сургалт хариуцагч багш, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөлөлөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь улирал бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүр асуудлыг ярилцаж шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.

- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (*Faculty development*), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

8.3 Сургалтын танилцуулга (*Orientation*)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрийн агуулгийн уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношлогооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

Хавсралт 1

360 хэмийн үнэлгээний хуудас

Суралцагч эмчийн нэр _____

Үнэлгээ хийг ☐ Эмнэлзүйн сургагч ☐ Багш ☐ Вилагч ☐ Бусад _____

☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Үнэлэх боломжгүй	Ховор(<19%)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (>80%)

Өвчтөн гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Нүүр амны мэс заслын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн журнал клуб, эмнэл зүйн хэлэлцүүлэгт идэвхитэй оролцдог	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4

Орон нутгийн болон бусад эмнэлгийн мэргэжил нэгт эмч нартай хамтран ажилладаг, сурсан мэдлэгээ хуваалцдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх бусад эмч, сувилагч, мэргэжилтэнтэй, хамтран ажилладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: “Тэр бол найдваргүй” гэн нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: “Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй”

Өөрөөсөө асуу: **Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?**

Хавсралт 2

Явцын Mini-CEX үнэлгээний хуудас

Он, сар, өдөр / /

Суралцагч эмчийн нэр: _____
нэр _____

Үнэлэгчийн

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: ☐Клиник
☐Тасаг ☐ЯТТ ☐

Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: ☐ эр ☐ эм

Өвчтөний зовиур: ☐ Халуурах ☐ Толгой өвдөх ☐ Дотор муухайрах ☐ Ухаан алдалт ☐
Амьсгаадалт ☐ Цээжээр өвдөх ☐ Амьсгалын зам саадтай болох ☐ Залгих үйл алдагдах
☐ Зажлах үйл алдагдах ☐ Нүд бүлтийх ☐ Нүд хоёрлож харах ☐ Татах ☐ Шингэн алдалт ☐
Зүрх зогсолт ☐ Хаван ☐ Үрэвслийн гаралтай арьс улайлт ☐ Ам ангайлт хязгаарлагдах ☐
Цус алдалт ☐ Лимфийн булчирхай томролт ☐ Сэтгэл гутрал ☐ Хүзүүний албадмал
байрлал ☐ Эрүүний мултрал ☐ _____

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

--	--	--

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа хэлнэ үү.
Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: □

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношлогоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Үнэлэгчийн гарын үсэг: _____ Суралцагч эмчийн гарын
үсэг: _____

Хангалттай гэж тодорхойлоход хэрэгэлэгдэх үзүүлэлт

Өвчтөний түүх авах	• Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. • Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу үзүүлдэг • Өвчтөний дохио зангааг ойлгож тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	• Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. • Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Эмнэлзүйн менежмент	• Зөв онош тавьдаг. • Оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг • Тохирсон эмчилгээ эхлүүлдэг. • Бусад нарийн мэргэжлийн эмч нартай хамтарч үзлэг эмчилгээг хэлэлцэж, шаардлагатай бол тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлж, хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог. • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг. • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	• Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. •

**Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт
(DOPS)-ын үнэлгээний хуудас**

Он, сар, өдөр / /

Суралцагч эмчийн нэр: _____
нэр _____

Үнэлэгчийн

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: ☐ Клиник
☐ Тасаг ☐ ЯТТ ☐

Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: ☐ эр ☐ эм

Гардан үйлдэл: ☐ Амьсгалын зам чөлөөлөх ☐ Өвчний түүх нээх ☐ Оёдол тавих ☐ Буглаа нээх ☐ Нэвчээс нээх ☐ Шархны боолт хийх ☐ Саатсан шүд авах ☐ Ёзоор авах ☐ Чиг тавих ☐ Шарханд анхдагч цэгцлэлт хийх ☐ Хамар ясны хугарал засах ☐ Рентген зураг унших ☐ Толойн боолт хийх ☐ Шанаа ясны хугарал хадах ☐ Эрүүний ясны хугарал хадах ☐ Шүлсний булчирхайн цоргоны амсар сэтгүүрдэх ☐ Ёзоор авах ☐ Хавдраас эд, эсийн шинжилгээ авах ☐ Жижиг хоргүй хавдар авах ☐ Уйланхай авах (цистотомия) ☐

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийн хийсэн тоо _____

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй, үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөр зөвшөөрлийн хуудас бөглүүлдэг				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг, багаж материалын сонголтоо зөв хийж бэлддэг				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж хийдэг				
Арга техник чадварлаг гүйцэтгэдэг, зөв байрлал эвээр зөв хийдэг				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг				

Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг				
Зөвлөгөө өгч, хяналт тавидаг				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

Суралцагч эмчийн үйлдлийн сайн талууд: ----- ----- ----- -----
Суралцагч эмчийн үйлдэлд сайжруулахад чиглэсэн зөвлөгөө: ----- ----- ----- ----- -----
Суралцагч эмчид өгөх эцсийн санал (нэгийг сонгох): ☐ Үйлдлийг гүйцэтгэх мэдлэг, чадвар хангалтгүй ☐ Сургагч багшийн хяналтанд үйлдлийг хийх /хянах түвшинг сургагч багш шийдвэрлэнэ/ ☐ Суралцагч эмч үйлдлийг бие даан хийх боломжтой ☐ Суралцагч эмч энэхүү үйлдлийг бусдад заах/бусдыг хянах боломжтой
Суралцагч эмчид өгөх БУСАД санал: ----- ----- -----

DOPS үнэлгээ хийсэн хугацаа: ____ /мин/. **Зөвлөгөө** өгсөн хугацаа ____ /мин/

DOPS үнэлгээ хийсэн **БАГШИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

DOPS -р үнэлүүлсэн **СУРАЛЦАГЧ ЭМЧИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

Багшийн гарын үсэг: _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

Санамж:

САНАМЖ: “Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт	
Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт, анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэдэх	• Сургагч багшид үйлдлийн заалт, эсрэг заалт, холбогдох морфологи анатомийн бүтэц, үйлдлийн үе шат, үйлдлийг гүйцэтгэх аргачлал, хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн заалт, эсрэг заалт, гаж нөлөө, болзошгүй эрсдэл, хүндрэлийн үеийн яаралтай тусламжийн талаар мэдлэгтэй, бүрэн тайлбарлаж чаддаг.
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрөл /зөвшөөрлийн хуудас авах	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчид үйлдлийн талаар бүрэн гүйцэд, дэлгэрэнгүй, ойлгомжтой, энгийн үг хэллэг ашиглан зохих тайлбарыг өгдөг. • Өвчтөн үйлдлээс айсан, сэтгэл нь тогтворгүй, түгшсэн тохиолдолд зовнилыг ойлгож, хуваалцаж, хүндэтгэлтэй, тэвчээртэй ханддаг, сонирхсон асуултанд оновчтой хариулдаг. • Зөвшөөрлийн хуудас бөглөхөөс өмнө өвчтөн нь гардан үйлдлийн талаар зохих ойлголттой байгаа талаар нягталдаг. • Өвчтөнд итгэл, үнэмшил төрүүлдэг. • Өвчтөнөөс шаардлагатай ажилбарт зөвшөөрлийн хуудас бөглүүлдэг.
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлэх	• Гардан үйлдлийг гүйцэтгэх төлөвлөгөөтэй. • Өвчтөний сэтгэл санаа, тайван байдлыг хангадаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэдэг. • Ажилбарын өмнөх хяналтын хуудас бөглөдөг, ажилбарын явц болон ажилбарын дараахь хяналтын хуудас, бичиг баримтыг бэлтгэдэг. • Гардан үйлдэлд шаардлагатай хувцас, өмсгөлийг бэлтгэдэг. • Үйлдлийг гүйцэтгэхэд найрсаг, ээлтэй, дулаан, байгалийн гэрэлтэй, цэвэр орчин бүрдүүлдэг.
Өвчтөний аюулгүй байдлыг хангах	• Гардан үйлдэл хийгдэх өвчтөний овог, нэр, регистрийн дугаар болон бусад аргуудаар танин тодруулдаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд хэрэглэх/хэрэглэж болзошгүй тайвшруулах, мэдээ алдуулах эм, тарианы нэр, тун, хэрэглэх арга зэрэг чанар, аюулгүй байдлыг хангадаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд зөв зүү, тариурыг сонгож нягталдаг, чанар, аюулгүй байдлыг хангадаг.
Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйжүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэх	• Ариун бээлийг зөв задалж өмсөж, тайлдаг. • Ариун салфетка, ариун хөвөн бөмбөлөг, нэг удаагийн зүү, тариуртай зөв харьцдаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай халдваргүйжүүлэх уусмалыг зөв ашигладаг. • Үйлдлийн талбайг зөв ариутгадаг. • Хурц үзүүртэй зүү, эмнэлгийн хэрэгслийг зөв ашиглаж устгадаг.
Гардан үйлдлийн арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэх	• Гардан үйлдлийн стандарт, протоколыг чанд мөрддөг. • Гардан үйлдлийг өөртөө итгэлтэй, чадварлаг гүйцэтгэдэг. • Зааварчилгааг тод, чанга дуугаар, ойлгомжтой өгдөг. • Зүү, тариур, тоног төхөөрөмжийг чадамгай ашигладаг. • Цус алдах болон бусад эрсдлээс сэргийлдэг.
Гардан үйлдэл амжилтгүй байгааг	• Үйлдэл амжилтгүй байгааг өвчтөн, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сандарч тэвдэлгүй, зөв зохистой ойлгуулж мэдээлдэг.

ойлгож, шаардлагатай үед тусламж дуудах	• Үйлдэл амжилтгүй гүйцэтгэсэнээ хүлээн зөвшөөрдөг. • Өвчтөн болон ажилчидтай тайван, зохистой харьцдаг. • Гардан үйлдлийг илүү сайн гүйцэтгэхэд бусдын тусламжийг хүсэж чаддаг. • Цаашид илүү амжилттай суралцах шаардлагатайг ухамсарладаг.
Үйлдлийн дараахь менежментыг зохистой хангах	• Суралцагч эмч нь гүйцэтгэсэн гардан үйлдэлд бодит үнэлгээ дүгнэлтийг өгч чаддаг. • Үйлдлийн дараахь эмчилгээ, асаргаа сувилгаа, халдвар хяналтын зөвлөмжийг өвчтөн болон эмнэлгийн ажилчдад амаар болон бичгээр зөв өгдөг.
Үйлдлийн үеийн харилцааны ур чадвар, хандлага	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог, зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг, эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг. • Эмнэлгийн ажилчидтай хүндэтгэлтэй, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж харьцдаг. • Хувь хүний нууцыг чанд сахидаг.
Үйлдлийн эмх цэгцийг хангах	• Гардан үйлдлийн бүх үе шат нь тайван, эмх цэгцтэй, дэс дараатай гүйцэтгэдэг
Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд гаргацтай цаг хугацаанд нь хөтлөх	• Гардан үйлдлийг зохих журам, зааврын дагуу баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтын огноо, цаг, үг, өгүүлбэрийг тодорхой, гаргацтай бичдэг. • Гардан үйлдэл гүйцэтгэсэн суралцагч эмч нь нэр, гарын үсгээ тодорхой, гаргац сайтай баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтыг сургагч багшаар баталгаажуулдаг.
Гардан үйлдэл хийх ерөнхий ур чадвар	• Өвчтөний аюулгүй байдлыг үйлдлийн бүх үе шатанд тасралтгүй хангадаг. • Гардан үйлдэл гүйцэтгэх мэдлэг хангалттай. • Гардан үйлдлийн ур чадвар хангалттай. • Гардан үйлдлийн үед гаргах шийдвэр, зааварчилгаа нь зөв. • Холбогдох тоног төхөөрөмж, нөөцийг зөв, зохистой ашигладаг.

НОМ ЗҮЙ:

- Pediatric Oral and Maxillofacial Surgery. Leonard B. Kaban, Maria J. Troulis
- Oral and Maxillofacial surgery. Archer
- Contemporary Oral and Maxillofacial Surgery 6th ed. James R. Hupp, Edward Ellis.
- Oral.Radiology.Principles and Interpretation 6th ed. Stuart C. White, Michael J. Pharoah
- Atlas of Operative oral and maxillofacial surgery Christopher J. Haggerty, Robert M. Laughlin
- Clinical Review of Oral and Maxillofacial Surgery Shahrokh C. Bagheri, Chris Jo
- Handbook of Local Anesthesia 6th ed. Stanley F. Malamed
- Medical Emergencies in the Dental Office 6th ed. Stanley F. Malamed
- Panoramic Radiology Allan G.Farman